



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот


Г Нийслэлийн өмчийн бүртгэлээс хөрөнгө Г  
хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын баланст бүртгэлтэй Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах нийт 15,629,792.75 (арван таван сая зургаан зуун хорин есөн мянга долоон зуун ерэн хоёр төгрөг далан таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад дурдсан 4 ус түгээх байрыг буулгаж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110160159

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 18  
дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| №                                 | Эд хөрөнгийн нэр   | Байршил                       | Ашигласан жил | Нийт үнэ             | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Мэргэжлийн улсын байцаагчийн дүгнэлт   |
|-----------------------------------|--------------------|-------------------------------|---------------|----------------------|--------------------|--------------|--|
| 1                                 | Ус түгээх байр 476 | Баянзүрх дүүргийн 14-р хороо  | 46            | 570,243.24           | 570,243.24         | -            | 2020 оны 02-07-118/1341 дүгээр дүгнэлт |
| 2                                 | Ус түгээх байр 101 | Чингэлтэй дүүргийн 15-р хороо | 43            | 4,205,013.94         | 2,286,417.57       | 1,918,596.37 | 2021 оны 02-07-081/878 дугаар дүгнэлт  |
| 3                                 | Ус түгээх байр 105 | Чингэлтэй дүүргийн 13-р хороо | 42            | 7,183,246.14         | 2,082,090.08       | 5,101,156.06 | 2021 оны 02-07-081/878 дугаар дүгнэлт  |
| 4                                 | Ус түгээх байр 194 | Чингэлтэй дүүргийн 13-р хороо | 9             | 3,671,289.43         | 2,448,289.04       | 1,223,000.39 | 2021 оны 02-07-081/878 дугаар дүгнэлт  |
| Актлах барилга, байгууламжийн дүн |                    |                               |               | <b>15,629,792.75</b> | 7,387,039.93       | 8,242,752.82 |  |